

МОНГОЛЫН СОЁЛ, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛД Ю.ЦЭДЭНБАЛЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Ц.Жамбалсүрэн.

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Өгүүллийн товч утга: Монголын нам, төрийн дээд удирдлагад 44 жил ажилласан Ю.Цэдэнбалын Монгол улсын соёл, боловсрол, шинжлэх ухааны хөгжилд оруулсан хувь нэмрийг хураангуйлан дүгнэсэн болно.

Түлхүүр үг: Бага, дунд, их, дээд сургууль, кирилл бичиг, уйгаржин монгол бичиг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах тогтолцоо, сэхээтний төөрөгдөл, намын эсрэг бүлэг.

1921 оны ардын хувьсгалын үр дүнд монгол орон сэргэн мандах замдаа баттай орж, үндэсний тусгаар тогтнолоо бэхжүүлэх, нийгэм-эдийн засгаа өөд нь татах, соёл боловсролоо хөгжүүлэх зорилтыг тууштай хэрэгжүүлж, анхны сургуулийг төв, орон нутагт нээсэн юм. Эдгээрийн нэг нь болох Улаангомын бага сургууль, Ховдын дунд сургуулийн анхны сурагчдын нэг Ю.Цэдэнбал гадаад орнуудад мэргэжилтэн бэлтгэх нам, засгийн бодлогоор ЗХУ-д эрдмийн аянаа эхэлжээ.

Тэрбээр ЗХУ-д дунд, дээд сургуульд нийт 10 жил тасралтгүй суралцаж, тухайн цаг үедээ чамлахааргүй өндөр боловсрол эзэмшжээ. Монголын анхны марканд зургаа татуулж, хичээнгүй чанартай, номын амтанд шимтсэн монгол хүү багш нарынхаа хайр хүндэтгэл хүлээж, өрлөг жанжин Х.Чойбалсангаас шагнал гардан хүртэж¹, сурлага сахилга сайтай оюутан байсны тулд Москва, Ленинград, Хар далайд амрах эрхийн бичгээр 2 удаа шагнагдаж², сургууль төгссөний дараа эрдэм шинжилгээний ажил хийх, аспирантурт суралцахаар Москвад хөөцөлдөж явахад нь эх орон нь дуудаж, чухам энэ үеэс түүний ажил хөдөлмөрийн гараа эхэлжээ.

Монголдоо анхны дээд боловсролтой эдийн засагч болсон Ю.Цэдэнбал тэр үедээ эрдмийн том уурхайд тооцогдож байсан Санхүү, эдийн засгийн техникумын хичээлийн эрхлэгч болж, боловсролын салбарт ажлын гараагаа эхэлсэн нь хожмын жилүүдэд соёл боловсролын байгууллагад тун анхааралтай, элэгтэй хандах болсны нэг үндэс нь болжээ. Удалгүй тэрээр Сангийн яамны орлогч сайд, жинхэнэ сайдын албанд дэвшиж ажилласан юм.

1940 он бол Монгол улсын түүхийн нэн чухал зааг үе байлаа. Үндэсний ардчилсан шинжтэй өөрчлөлтүүд хийгдэж, манай орон хөгжлийн шинэ зурвас үед орж, эрдэм боловсролтой хүн юу юунаас чухал байв. Баруунтан, зүүнтэн, хэлмэгдүүлэлт гэсэн үйл явдалд гар хуруу дүрээгүй шинэ залуу боловсон хүчин ихээхэн шаардагдаж байв. Ю.Цэдэнбалын гэр бүлийн алтан багана болсон нагац ах Цэвэлжин хэлмэгдэн буудагдсан, хүү Гэжээ нь шоронд орсон зэрэг байдлын улмаас хүнийг хэлмэгдүүлэн хохироох байдлыг залуу Цэдэнбал гаргахгүй байх гэсэн найдварыг тэр үеийн удирдагч Чойбалсанд төрүүлсэн бололтой. Дэлхийн дайн дэгдэж, тусгаар тогтнолоо бэхжүүлэх, ЗХУ-тай найрамдал нөхөрлөлөө зузаатгаж чадах зөвлөлтөд элэгтэй хүн удирдлагад хэрэгтэй байлаа. Мөн баруун хязгаарын ард түмний дунд гарч байсан зарим дургүйцлийг намжаах, ястнуудын эв нэгдлийг зузаатгах шаардлагын үүднээс бага ястнуудаас удирдлагад дэвшүүлэх нь мөн л зүйтэй байжээ. Монголын тэр үеийн гол удирдагч Х.Чойбалсан дээрх шаардлагуудыг харгалзан залуу Цэдэнбалтай биечлэн нарийн танилцаж, шалган туршиж, бас ч гэж зөвлөлтийн багш нарын үг, албаны хүмүүсийн санал бодлыг ч судалж, бүр И.В.Сталинд үзүүлж танилцуулах үндсэн

¹ Хүмүүн толь. (Ю.Цэдэнбалын өвийг хамгаалах судлах сангийн хэвлэл). 1993., №1

² Л.Шинкарев. Цэдэнбал, Филатова хоёр: хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл. УБ., 2004., т 35

дээр Ю.Цэдэнбалыг МАХН-ын удирдлагад хөтлөн, дэвшүүлж гаргаж ирсэн ажээ³.

Эрх баригч намын шинэ залуу даргын эн тэргүүний зорилт бол эх орондоо соёл гэгээрлийг хөгжүүлэх, боловсролыг төр, засаг намын анхаарлын төвд тавих, хөдөлмөрчдөд, ялангуяа залуу үеийг эх оронч иргэнлэг үзэл, эв нэгдэл, энх тайвны үзлээр хүмүүжүүлэх явдал байв. Ю.Цэдэнбал МХЗЭ-ийн 1940 оны IV бүгд хуралд хэлсэн үгэндээ: "НТХ, СнЗ-өөс сум бүрт сургууль байгуулах тогтоол гаргаж, энэ жил зун ба өвлийн нийлсэн бүгд 217 сургууль байгуулахаар тогтоон явуулж байна. Ямар ч улс нэг жилд өдий чинээ сургууль байгуулсан түүх үгүй байнам. Бид үүнийг онцгойгоор үнэлэн үзэх хэрэгтэй. Энэ жил 50000 хүнийг бичиг үсэгт сургах төлөвлөгөөтэй байна. Соёлын фронт бол ажлын өргөн талбар мөн"⁴ гэж нам, улс, ард түмний өмнө зогсож байсан нэн тэргүүний зорилтыг тодорхойлжээ.

Үндэсний уйгаржин монгол бичгээ өөрчилсний буруутан нь Ю.Цэдэнбал гэж нэг хэсэг хүн бичиж ярьж байсан нь нэг талаас харсан ойлголт болов уу. 1930 онд Улсын VI их хурал монгол үсгийг халж, латин үсэгт шилжих шийдвэр гаргаж байхад тэрээр 14 настай сурагч байсан, намын X их хурал дээр Х.Чойбалсан "Хуучин Монгол үсгийг сольж, латин үсэг хэрэглэх" тухай ярьж шийдвэрлэж байхад тэрээр жирийн төлөөлөгч л чагнаж байсныг түүх сонирхдог бүх хүмүүс мэдэх билээ. Харин 1941 онд монголын удирдлага Төв Азийн нүүдэлчдийн тамга үсгээс гаралтай гэгддэг кирилл үсгийг авч хэрэглэх шийдвэр гаргахад тэрээр оролцсон нь мэдээж юм. Үндэсний бичгээ орхисон нь харамсалтай байвч энэ шинэ бичиг үсэг монголчуудад ач буянаа өгсөн гэдэгтэй маргах хүн байхгүй бизээ. Дашрамд хэлэхэд Ю.Цэдэнбал амьдралын сүүлчийн мөч хүртлээ төрөлх уйгаржин монгол бичгээ голлон идэвхтэй хэрэглэж байсны нотолгоо болсон янз бүрийн тэмдэглэлүүд нь хадгалагдан үлджээ.

Хүн амын дөнгөж арав гаруйхан хувь нь бичиг үсгээ халтар хултар мэддэг, урьдын олон жилийн ядуурал, хоцрогдол, дайн дажин, алдаа гажуудлын зовлонд нэрвэгдсэн, эдийн засаг, санхүүгийн боломж тун дорой оронд хүн ардаа бичигтэн болгох зорилтыг хэрэгжүүлэх тэмцлийг тэр үеийн монголын удирдагчид, түүний нэг болох намын дарга шийдмэг зоригтойгоор эхэлжээ. Тавиад оны сүүлчээр энэ зорилгоо хэрэгжүүлж, Монгол нь бичиг үсэг үл мэдэх явдлыг устгасан Азийн анхны орон болж ЮНЕСКО-ын шагнал хүртэж байсныг сайн судалж сургамж авбал зүгээр билээ.

(МАХН-ын залуу удирдагчийн эн тэргүүний зорилт бол залуу үеийг эрдэм мэдлэгтэй, эх оронч үзэлтэй болгон хүмүүжүүлэх явдал бөгөөд боловсрол, соёлын асуудал Ерөнхий нарийн бичгийн даргын шууд хариуцдаг салбар байлаа. Багшлах ажлаас гараагаа эхэлсэн Ю.Цэдэнбал бүр анхнаасаа боловсрол бол бодлогын тэргүүлэх салбар гэж үзэж байсан билээ. 1940 оны 12 сарын 6-нд СнЗ "Улаанбаатар хотноо улсын университет байгуулах тухай" 45(6)-р тогтоол гаргаж⁵, улмаар 1942 оны X сарын 5-нд МУИС-ийг нээх ёслол Лениний нэрэмжит клубт болжээ. Тус баярын цуглаанд Дээд сургуульд суралцагсдын суралцах зорилгын тухай илтгэлийг НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал тавьж, Маршал Х.Чойбалсангийн хүндэт сануулгыг чагнаж, ШУХ-ийн баярын бичгийг уншиж танилцуулжээ.

1943 оны 5 сарын 20-нд НТХ-ны Тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан хурлаас УИС-ийн хичээлийн байр барьж, яаралтай дуусгах талаар тогтоол гаргаж, НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал, Ерөнхий сайд, Маршал Х.Чойбалсан гарын үсэг зуржээ. Барилгын ажлыг түргэтгэх холбогдох заалтуудыг тэд бас гаргажээ. МУИС-ийн анхны төгсөлтийн хуралд Ю.Цэдэнбал мөн оролцож

³ Л.Бат-Очир. Чойбалсан. УБ., 1996. с 159-160

⁴ Ю.Цэдэнбал. МАХН-ын үзэл суртлын үйл ажиллагааны тухай. УБ., 1980., т 8

⁵ УИС-ийн архив. 1942, хавтас 1, № 7; Г.Загд. МУИС-ийн түүхээс. 1968., т 12

баяр хүргэжээ. Монголын ард түмний бахархал болсон МУИС нам, төрийн удирдагчдын байнгын халамжинд байлаа.

Ялангуяа МУИС-ийг багшлах боловсон хүчин, удирдлагаар хангахад Ю.Цэдэнбал онцгой анхаарч байв. МУИС-ийн ректороор, Эрхүүд цуг сурч байсан нэрт эрдэмтэн, түүхч төр, нийгмийн зүтгэлтэн Б.Ширэндэвийг томилж байв. Ю.Цэдэнбал МУИС-ийг бэхжүүлэхэд цаг ямагт анхаарал тавьж, монголын эрдэм мэдлэгийн гол уурхай болсон энэ сургуульд тун элэгсгээр хандаж, өөрөөс шалтгаалах бүхнээр тусалж байжээ. Энэ тухай академич Н.Содном "Монгол улсын университет" номынхоо "Буянтай учрал" бүлэгтээ Ю.Цэдэнбалтай уулзаж саналаа хэлсний ачаар "улсын 60 жилийн ойгоор урьд үзэгдээгүй олон багш нар төр, засгийн шагнал авч, дараа нь түүхэнд үзэгдээгүй олон орон сууцыг МУИС-д бэлэглэсэн юмаа. МУИС-д тус бүр 300 хүн суух оюутны байр гурвыг, багш нарын 48 айлын орон сууц хоёрыг улсаас бариулж өглөө. Цэдэнбал дарга их сургуулиа мартсангүй"⁶ гэж тэмдэглэж байжээ.

Академич О.Шагдарсүрэн дурсахдаа: "1982 онд би МУИС-ийн ректор болох үеэр Бал дарга бид хоёр шинжлэх ухаан, боловсролын хэд хэдэн асуудлын талаар ярилцсан билээ. Тэгэхэд Цэдэнбал дарга: их сургуулийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд их анхаар. Ялангуяа чи тэр орос хэл дээр хичээл заадаг улсынхаа чадварыг дээшлүүлээрэй. Дэлхийн шинжлэх ухааны чухал хэл шүү гэж захиж байлаа. Тэрээр: МУИС ч өргөжих ёстой. Эрдмийн энэ өргөөнд ардын хүүхэд улам олноор сурах хэрэгтэй. Их сургуулийг бэхжүүлэх санаа төлөвлөгөөг чинь би дэмжинэ гэв. Ю.Цэдэнбал МУИС-ийг санаачлагч, зохион байгуулагчийн нэг, их сургуулийн нээлтийн хурал дээр их сургуулийн зорилгыг тодорхойлсон гол илтгэлийг тавьсан хүний хувьд их сургуулиараа бахархаж, цаг ямагт санаа тавьж, тулгарсан асуудлыг шууд шийдэж өгдөг хүн байж билээ.

Цэдэнбал дарга өр нь ШУА, МУИС-ийн эрдэмтдийг байнга урьж уулздаг, үүндээ их дуртай хүн байсан. Ялангуяа Б.Ширэндэв, Д.Цэвэгмид, Ж.Батмөнх, Н.Содном, Хурметбек бидэнд их дотно хүндэтгэлтэй ханддаг байсан юм. Заримдаа албан яриа, уулзалтад биш, ерийн ярилцаж зөвлөлдөхийн тулд ч биднийг гэнэт урьчихдаг сонин зантай энгийн хүн байв ..." ⁷ гэжээ.

Намын Төв Хорооны шийдвэрээр 1941 онд Нам, улсын төв сургууль гэж байсныг Намын шинэ хүчний дээд сургууль болгон өөрчилж суралцах хугацааг нь 4 жил болгосон бөгөөд энэ сургуульд Ю.Цэдэнбал Улс төрийн эдийн засгийн ухааны хичээл зааж, Марксын "Капитал" зохиолоор тойм лекц уншиж, элсэлт, төгсөлтийн шалгалт авч, нам, улсын боловсон хүчин бэлтгэхэд биечлэн оролцож хувь нэмэр оруулж байжээ.

Намын Төв Хороо, Цэргийн Улс төрийн газрын шийдвэрээр 1943 онд Цэргийн ерөнхий сургуулийг өргөтгөн, Сүхбаатарын нэрэмжит офицерийн сургууль болгож цэргийн дарга нарыг бэлтгэх болов. Ийнхүү боловсон хүчин бэлтгэх системийг үндсээр нь шинэчлэн өөрчлөх бодлогыг Ю.Цэдэнбал тууштай хэрэгжүүлсэн юм.

Боловсрол бол хөгжлийн үүд хаалга, нийгмийн урагшлах хөдөлгөөний бат үндэс гэж тэрбээр хатуу итгэж байснаас сургууль соёлын газрыг төр, засгийн шууд ивээлд авч байлаа. Монголын буурал түүхэнд Цэдэнбалын үеийнх шиг олон сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын ордон, кино, театр, номын сан байгуулагдаж байсан үе байхгүй гэж хэлж болох юм. 1940-1985 онд шинээр ЕБС 580, ТМС 40, техникум 21, их дээд сургууль 8-ыг⁸ байгуулахын тулд нам, төр, засаг асар их хөрөнгө, хүч зарцуулж, өр бусын хүчин чармайлт гаргасан бөгөөд эдгээрийг байнга тогтвортой ажиллуулж, бэхжүүлж, багшаар хангаж ирсний дүнд

⁶ Н.Содном. Монгол Улсын Университет. УБ., 2003, т 71-72

⁷ Зохиогчийн хувийн архив. (ЗХА)

⁸ БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжил 1988 онд: стат. эмхтгэл. УБ., 1989., т 94

энэ хугацаанд сургуульд суралцагчдын тоо 28 мянгаас 511 мянга болтлоо өсөж⁹, дөрвөн хүний нэг нь аль нэг сургуульд сурдаг, ард түмнийхээ үр хүүхдийг үнэ төлбөргүй сургадаг, боловсрол өөдлөн цэцэглэсэн орон болсон юм.

Дотоод бололцоог шавхан дайчлахаас гадна Ю.Цэдэнбал ба түүний хамтран зүтгэгчид сайн санааны эв хичээсэн бодлогоороо бусад хөгжилтэй хүчирхэг ард түмнүүдийн дэмжлэг хүлээж, Европ, Азийн арав гаруй оронд жил бүр арван мянга гаруй охид, хөвгүүдийг өөрсдөөс нь ганц ч төгрөг гаргалгүй бараг тэдгээр орны хөрөнгөөр сургаж, эх орныхоо мэргэжилтний алтан фондыг арвижуулсан юм. Ардын засгийн жилүүдэд /1921-1985 онд/ зөвхөн Зөвлөлтийн их, дээд, дунд сургуулиуд монголын 30 мянга гаруй охид, хөвгүүдэд мэргэжил мэдлэг, боловсрол, соёл олгосныг бид ахмад үеийн ачтан буурлуудын бодлого, буянт үйлстэй холбож ойлгох нь түүхийн үнэнд нийцэх биз ээ.

1940 онд багш, эмнэлгийн эмч, сувилагч ажилчид, санхүү, дансны ажилчид, худалдааны ажилчин, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, их төлөв дамжаагаар бэлтгэгдсэн үндэсний шинэ хүчнүүд хэмээх 6000 гаруйхан хүн ажиллаж байсан бол 1983 оны байдлаар дээд мэргэжилтэй 60 мянга, тусгай, дунд боловсролтой 70 мянган боловсон хүчнээс гадна ТМС, жилийн дамжаа төгссөн олон зуун мянган хүн ажиллаж байлаа.

Ю.Цэдэнбал олон арван жилийн турш тууштай бэлтгэсэн боловсон хүчнийг "үнэт алтан фонд" гэж үзэж, үндэсний сэхээтний армитай болсныг томоохон ололтод тооцож, "Бүх ажил, бүх бодлогын хувь заяаг боловсон хүчин шийдвэрлэнэ" гэж зааж, тэднийг хайрлаж, анхааран халамжлахыг цаг ямагт захиж хэлж, тийм үлгэр дуурайллыг өөрөө үзүүлж байлаа. Мэдээж тэдэнд өндөр шаардлага тавьж, байнга тусалж байхыг, ялангуяа тэднийг эх орон, ард түмнийхээ төлөө үнэнч, шудрага зүтгэдэг болгон хүмүүжүүлэхийг амин чухал зорилт гэж номлож, сургамжилж байлаа. Тэр үеийн сэхээтнүүд өөрийн бүх хүч мэдлэгээ эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө шавхан дайчилж, ажиллаж байсан гэж хэлэх нь шудрага үнэнд нийцнэ.

Боловсролын хөгжилтийг дагаж шинжлэх ухаан хөгжсөн бөгөөд Ю.Цэдэнбалын баг улс орны амин чухал аливаа асуудлыг юуны өмнө гол төлөв үндэсний эрдэмтэдтэйгээ зөвлөж, тэдний санал хүсэлтийг гаргуулж, судалгаа туршилт явуулах үндсэн дээр шийдвэрлэн хэрэгжүүлж байсан сонирхолтой өв сургамж өнөө үеийнхэнд ч хэрэгтэй юм. Эдийн засагч эрдэмтэдийн зөв нарийн тооцоо судалгааны дүнд 1940-1985 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 50 дахин, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 244 дахин, бүх төрлийн тээврийн ачаа эргэлт 581 дахин, барилга угсралтын ажлын хэмжээ 210 дахин өссөн нь эдийн засгийн шинжлэх ухаан манайд муугүй хөгжсөнийг харуулах биз ээ¹⁰.

Монголын эрдэмтэд, эмч нар ард түмнээ эрүүлжүүлж чадсаны дүнд хүн амын тоо 1940 онд 738 мянга байснаа 1984 онд 1 сая 820 мянгад¹¹ хүрч, монгол үндэстэн өсөн өнөржиж, бүл чадал нэмэгдсэнийг сайн судалж сургамж авах нь зүйтэй биз ээ. Монголын эрдэмтэд шинэ үүлдрийн мал, шинэ сортын ургамал гаргаж, Антарктидыг судалж, сансрын уудмыг эзэмших программ хэрэгжүүлж, сансарт хүн нисгэсэн дэлхийн арваадхан орны нэг болов.

МАХН-ын Төв Хороо 1960 оны 10 сарын 13-нд Шинжлэх ухааны Академийг 1961 онд байгуулах түүхэн шийдвэр гаргаж, НТХ, СнЗ 1960 оны 10 сарын 20 нд "ШУА байгуулах бэлтгэл ажлын тухай" тогтоол гаргажээ. 1961 оны V сарын 16 нд "АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар ШУА байгуулахаар шийдвэрлэж, улмаар 1961 оны V сарын 22 нд Сайд нарын Зөвлөл ШУА-ын

⁹ Мөн тэнд.

¹⁰ Зууны эрдэмтэд, академичид, алдартнуудын уриалга: Монголын нам, төр, засаг, цэргийн нэрт зүтгэлтэн Улсын Баатар, Хөдөлмөрийн Баатар, Улсын Маршал Ю.Цэдэнбалын өв дурсгалын тухай. УБ., 2003, т 8, 9

¹¹ Народное хозяйство МНР. 1924-1984. УБ., 1984, т 19

дүрмийг нь баталжээ¹². Эдгээр шийдвэрүүд гаргахад МАХН-ын Төв Хорооны I нарийн бичгийн дарга, СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал голлон оролцсон ажээ.

1961 оны V сарын 24 нд Шинжлэх ухааны академи нээх ёслолын хурал дээр үүсгэн байгуулагчдын нэгийн хувьд Ю.Цэдэнбал хэлсэн үгэндээ: ШУА байгуулж байгаа явдал бол социализм байгуулах хэрэгт манай орны хөдөлмөрчдийн олсон бас нэг сайхан ялалт мөн бөгөөд монголын ард түмний социалист соёлын хөгжлийн түүхэнд нэн том үе шат болж байна. ШУА-ийг зохион байгуулалтын хувьд эмхлэн байгуулсан нь манай эрдэмтэдийн их хуриуцлагатай ажлын зөвхөн эхлэлт юм¹³ гэжээ.

Ю.Цэдэнбал орчин үеийн Монголын шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар жинхэнэ эрдэмтэн хүний ёсоор хандаж анхаарал тавьж байсан хийгээд ШУА-ыг байгуулах талаар гарамгай үүрэг гүйцэтгэснийг үнэлж, түүнд ШУА-ийн хүндэт академич цол олгож, намын нийгэм эдийн засгийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх талаарх идэвхтэй үйл ажиллагааг нь өндөр үнэлж бүтээлээр нь эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг олгожээ. Энэ шийдвэрийг эрдэм шинжилгээний хүрээнийхэн баяртай хүлээн авчээ.

Хүн ардынхаа эрүүл мэндийг хамгаалах салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэхэд төр, засаг чадах чинээгээрээ зүтгэсэн юм. 1940 онд манай оронд орос, монгол нийлсэн дунд мэргэжилтэй нийт 108 эмч ажиллаж байсан бол АУДС байгуулж, үндэсний эмч нарыг бэлтгэж, бас гадаадад эмч нар бэлтгэх болсны дүнд 1985 онд 4595 их эмчтэй болж, 10000 хүнд ноогдох их эмч 1.5 байснаа 23 болж¹⁴, нэг их эмчид ноогдох хүний тоо гэсэн үзүүлэлтээр АНУ, Япон, Их Британи, Сингапур, Тайвантай зуузаа холбох болсныг чухал ололт гэж гадаад, дотоодынхон үздэг, бичдэг нь үндэстэй юм.

✦ Ю.Цэдэнбалын баг соёл, урлаг, утга зохиолыг хөгжүүлэх өргөн бололцоог бий болгохыг чармайсан юм. Чухам л энэ үед Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин, Ч.Подойдамба, Э.Оюун, Л.Түдэв, С.Удвал, Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн, С.Гончигсумлаа, Г.Хайдав, Ц.Пүрэвдорж, С.Норовбанзад, Б.Одон, Н.Чүлтэм, О.Цэвэгжав, Д.Амгалан, Ч.Ядамсүрэн нарын зуундаа төдийгүй мянганд алдарших гайхамшигт уран бүтээлчид төрөн гарсан юм. Соёл урлаг, утга зохиолын олон арван мастерууд Ю.Цэдэнбалтай ойр дотно, бүр удирдах багт нь орж, энэ салбаруудыг хөгжүүлэх талаар хамтран зүтгэж байсан билээ. Гадаадын уран зохиолыг орчуулж хэвлэх, нийтийн хүртээл болгох ажил ер нь оргил үедээ байв.

Монголын сэхээтний томоохон хэсэг зэвсэгт хүчний салбарт алба хааж байлаа. Дал, наяд онд цэргийн боловсон хүчний чадавх өсөв. Тусгай хороо, дивизийн захирагч, түүнтэй адил дээд тушаалын офицеруудын 80%, хороо батальон, дивизионы захирагч нарын 60% нь цэргийн дээд боловсролтой хүмүүс болов. Монголын армийн бүх офицерийн 35,3 % нь ЗХУ-д цэргийн академи, дээд, дунд сургууль төгссөн хүмүүс байв¹⁵. Энэхүү ахиц өөрчлөлт Улсыг батлан хамгаалах зөвлөлийн даргаар ажиллаж байсан /1941 оны Армийн комиссар, 1944 оны дэслэгч генерал/ Маршал Ю.Цэдэнбалын үйл ажиллагаатай шууд холбоотой байсан гэж хэлж болох юм.

Монголын нийгмийг удирдах хүчний үүрэг гүйцэтгэж байсан МАХН-ын удирдагчаар 40 гаруй жил ажиллахдаа Ю.Цэдэнбал намын удирдлагын үр нөлөө нь боловсон хүчний чадавхаас их шалтгаална гэж үзэж, намыг боловсон хүчнээр бэхжүүлэхэд онцгой анхаарал тавьж байлаа.

Эзэн Чингисийн үед Хурилтайн эрхэм гишүүн, мянганы ноён 90-ээд байсан бол Ю.Цэдэнбалын толгойлсон НТХ-ны гишүүн 90 хүн байсны дотор академич,

¹² Монгол Улсын шинжлэх ухаан. УБ., 2000, т 13

¹³ Ю.Цэдэнбал. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. 1967. II боть. т 513

¹⁴ БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжил 1988 онд. Стат. Эмхтгэл. УБ., 1989. т 103-104

¹⁵ БНМАУ-ын зэвсэгт хүчин. УБ., 1981, т 137

шинжлэх ухааны доктор, профессор, дэд доктор олон арав байжээ. Чингис хаан 9 өрлөг жанжинтай байсан бол ШУА-ийн академич, эдийн засгийн ухааны доктор Ю.Цэдэнбалын хамгийн ойр дотны хамтран зүтгэгчид болох УТТ-ны илүү ч үгүй, дутуу ч үгүй яг л 9 гишүүн байсны дотор хөдөө аж ахуйн эдийн засагч, академич Н.Жагварал, барилгын инженер, түүхийн ухааны доктор Д.Майдар, эдийн засагч, профессор Ж.Батмөнх, хуулийн доктор С.Жалан-Аажав багтаж байв.

Үүнээс үзэхэд монголын сэхээтэн, эрдэмтдийн нэлээн чадварлаг томоохон хэсгээр Ю.Цэдэнбал өөрийгөө хүрээлүүлж, тэд нараас байнга сурч, тэдний оюуны асар их чадавхийг төр, нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дайчлан ашиглаж, тэд нарыг түшиглэн ажиллаж байсан гэж хэлэхэд болох мэт санагдана.

Гэвч улс орны удирдах бүлэглэлийн дотоодод халаа солио, шинэчлэлт, залуужуулалт цаг үеийн шаардлагын дагуу мэдээж хийгдэж байсан бөгөөд энэ нь өөр намын, үзэл бодлын зөрүүтэй гэдгээр олон тоогоор хоморголох маягаар биш, гол төлөв онол шинжлэх ухааны мэдлэг, ажлын арга барилаар хоцрогдсон, хамт олон, удирдлагатай ажиллах харилцааны соёл, зан чанарын доголдолтой, тухайн үед нам, төрийн баримталж байсан бодлогын гол жанжин шугам, хамтын удирдлагын зарчим, намын эв нэгдэлд хохирол учруулсан зэрэг тодорхой шалтгаанаар л зарим хүмүүсийг удирдах ажлаас өөрчилж байжээ.

Тавиад оны монголын түүхийн ээдрээ будлиантай нэг асуудал бол өөрийн сэхээтнүүдийг хэлмэгдүүлж хохироосон явдал юм. Тэр үед ЗХУКН-ын XX их хурал, түүнчлэн Европын социалист орнуудад социализмыг шүүмжлэх уур амьсгал хүчтэй болсны нөлөөгөөр Монголын сэхээтнүүд ч улс орныхоо хөгжлийг хурдасгахад чиглэсэн санал шүүмжлэл өрнүүлжээ. Үүнд тухайн үеийн намын удирдлага, зөв зүйтэй дүгнэлт хийхийн оронд Намын Төв Хороо 1956 оны 12 дугаар сарын 5 нд "Манай намын бодлогод харш үзэл санаа, үг өгүүлэл гарч байгаа тухай" гэсэн улс төрийн алдаатай тогтоол гаргаж сэхээтнүүдийнхээ идэвх оюуныг дарсан байна.

Мэдээжээр энэ тогтоолыг санаачилж, боловсруулж гаргасан буруутай эзнийг олох авд олон хүн мордоцгоосон бөгөөд Дамба гуай хожим нь: "Тогтоол хийхэд Цэдэнбал, Төмөр-Очир, Ширэндэв нар оролцсон юм" хэмээн нэгдүгээр нарийн бичгийн даргад бараг л дуулдагуй хэрэг мэт зүйл ярьжээ. Гэтэл Б.Ширэндэв гуай хожим: "Цэдэнбал, Төмөр-Очир хоёр тогтоол гаргах гэж шуурхайлаад эхэллээ. Ерөнхий сайдын орлогч НТХ-ны тогтоол хийнэ гэж байхгүй. Харин би сэхээтнүүдээ хамгаалсан юм" хэмээн Ерөнхий сайдаа хэрэгт барьж өгөөд бултсан юм. Тэр үед ачааны хүндийг үүрч явсан Ерөнхий сайд, түүний сайн нөхөр Төмөр-Очир нар л энэ хэргийн буруутан болж "таарав".

Гэтэл Д.Дамба дурдатгалдаа: "Энэ тогтоол гарсны дараахан болсон Хотын намын идэвхтний хурал дээр Дамба мэтийн хүмүүс сэхээтнүүд руу довтолж байна гэж Ю.Цэдэнбал хэлчихсэн юм байжээ. Сүүлд нь дуулсан"¹⁶ гэж хэлснээс үзэхэд Ю.Цэдэнбал тухайн асуудлаар Д.Дамбыг шүүмжлэх байр суурьтай байсныг харуулж байна. Сэхээтнүүдийн санал бодолтой танилцсан уулзалт, яриануудын талаар академич Б.Ширэндэв 90-ээд онд өгсөн ярилцлагадаа: "Сэхээтний төөрөгдөл гэдэг яриа ЭТХ, УИС зэрэг хоёр гурван газар л гарсан юм. Цэдэнбал хүнтэй уулзаагүй. Хашир хүн л дээ. Дамба гуай, Самбуу гуай хоёр хотын намын хороо, Эвлэлийн Төв Хороон дээр очиж сэхээтнүүдтэй ярьсан байх. Би их сургууль дээр Балжинням, Самдан нартай хамт очсон. Цэдэнбал Дамба тэргүүтэй нам, засгийн төлөөлөгчид хойно очсон. Төлөөлөгчидтэй Хрушев, Суслов, Андропов нар ярьсан. Тэд: Танайд сэхээтний яриа гэгч гарч гэнэ, түүн дээр манайхыг элдвээр ярьсан байна. Танайд бид туслаж байсан, талсан юмгүй, учрыг олж засаж залруулна биз дээ. Ийм яриа Унгарт гараад байгаа, ийм ярианы үнэр Чехословакт ч бас гарч байгаа шүү гэсэн.

¹⁶ Үнэн. 1990.1.4

Сэхээтний ярианд Зөвлөлтийн эсрэг гарсан мэр сэр яриа хөөрөө байсан юм. Үүнийг хавтгайруулан цагаатгаж, тогтоолд буруушаасан бүхнийг үндэсгүй зүйл гэж хэлж бас болохгүй"¹⁷ гэжээ.

"Сэхээтний төөрөгдөл" гэгч хэрэг явдалтай Ерөнхий сайд Ю.Цэдэнбал ямар хамааралтайг судлахад хэрэг болохуйц баримт материалууд ч олдсоор байна. 1959 оны III бүгд хурал дээр Д.Дамбыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудал хэлэлцэж байхад Ю.Цэдэнбал хэлэхдээ: Дамба нь "Цэнд ийм муухай юм гаргасан. Төмөр-Очир ч сэхээтний төөрөгдөлд орсон гэдэг ойлголтыг төрүүлсэн. Энэ бол шууд гүтгэлэг мөн. Цэнд Намын Төв Хороог татан буулгана гэдэг асуудлыг оруулж байгаагүй. Харин Төв Хорооны зарим хэлтсийг татан буулгана гэсэн санал байсан. 1956 онд сэхээтний төөрөгдлийн элдэв үг ярианы дотор үнэтэй цэнэтэй сайн саналууд ч, муу муухай зүйлүүд ч байсан юм. Үүнийг ялган салгаж аваагүй тал бий. Энэ талаар энд тэнд хурал хийлгэж сэхээтний саналыг нилээд гаргуулж аваад сүүлдээ Төв Хорооны тогтоолд нилээд хатуу заасан. Тэр үед Төмөр-Очир зүйтэй саналууд гаргасан. Тогтоолд ингэж бөөнөөр нь авах нь (буруушаах нь гэсэн санаа болов уу) залуу сэхээтний идэвхийг таслахад хүргэнэ. Иймээс сайн мууг нь салгаж, дүгнэлт хийх хэрэгтэй гэсэн зөв зүйтэй саналыг гаргасан юм. Тэрнээс үндэслэж н. Дамба Төмөр-Очирт жаахан дургүй нь хүрвэл энийг гаргаж ирдэг болсон юм. Тэр үедээ ингэж тогтоол гаргаад өнгөрсөн юмыг дахин давтан гаргаж ирж байна"¹⁸ гэж тэмдэглэснээс сонирхолтой дүгнэлт гарч байна гэж хэлж болох юм.

Тавиад оны нийгэм улс төрийн томоохон зүтгэлтэн, хэлмэгдэн хохирч байсан хүн болох доктор Н.Дангаасүрэн хожим дурсахдаа: "Энэ хэрэгт хоёр зуугаад сэхээтнүүдийг холбогдуулан баривчлахаар Самбуу гуай, бид хоёрын үсгийг зуруулах гэхэд бид зөвшөөрөөгүй" хэмээн хотын намын идэвхтэнд Цэдэнбал дарга ярьсан гэж түүний туслах байсан дэд эрдэмтэн С.Ишдорж Академийн Намын Хорооны хурал дээр хэлсэн сураг бий" гэж хэлж байснаас үзэхэд сэхээтнүүдийг хоморголон цохилт өгөх гэсэн хар хүчин тэр үед байсан болон тэр эвгүй эргэлтээс Ж.Самбуу, Ю.Цэдэнбал нар сэрэмжлэн зайлуулжээ гэсэн дүгнэлт гарч байна.

Төөрөгдсөн сэхээтний хамгийн том төлөөлөгч гэгдэж, бараг л шоронд суухаас бусдыг үзсэн Дорж нь Ю.Цэдэнбалын хүргэн байжээ. Тавиад оны дунд үед болсон үйл явдлын гэрч Ө.Дорж гуай "Дурсамж, сургамж" номондоо "энэ үед Д.Дамба, Б.Ширэндэв нарын зэрэг хэсэг улс төрчид анх удаа "сэхээтний төөрөгдөл" гэгчийг санаанаасаа зохион гаргаж улс төржүүлэн, эх оронч үзэлтэй, үнэнч шударга ахмад, залуу олон зуун сэхээтний амыг албадан хааж, нэр төр, ажил амьдралаар нь хэлмэгдүүлснийг хэлэх хэрэгтэй. 1956 оны 11 сард МАХН-ын ТХ-ны бүгд хурал болж намайг хуралд суу гэж дуудлага ирлээ. Тэр өдөр би эмнэлэгт халуунтай хэвтэж байлаа. Энэ учраа хэлж хуралд очиж чадахгүй нь байна гэсэн чинь удсан ч үгүй эмнэлгийн дарга Батсүх, орос эмэгтэй эмч дагуулж орж ирээд танд тариа хийгээд бүгд хуралд яаралтай ирүүл гэж УТТ-оос даалгаж байна гээд тариа хийлээ. Би хуралд очиж суулаа. Хурал орой 8 цаг 30 минутанд эхлэв. Д.Дамба гуай илтгэл тавилаа. Намын бодлогод харш үзэл, үг, өгүүлэл гарсан гэсэн утгатай илтгэл байлаа. Илтгэлд олон хүний нэр, байгууллага гарсны дотор Дангаасүрэн, Содномцэрэн, Ө.Дорж, Төмөрбаатар, Лхамжав нарын зэрэг олон хүний нэр байлаа. Бүгд хуралд УТТ-ны гишүүд бүрэн бүрэлдэхүүнээр оролцож байв. Илтгэлийн дагуу санал шүүмжлэл явлаа. Дэмчиг, Лувсанчоймбол, Сурмаажав нараас элдэв үг яриа гаргасан хүмүүсийг баръя гэж байлаа"¹⁹ гэжээ. Гадаад яамны сайд Адилбиш, "Үнэн" сонины эрхлэгч Цо.Намсрай, Аж үйлдвэрийн сайд Бавуудорж, Тээврийн сайд Ядамсүрэн, НТХ-ны нарийн бичгийн

¹⁷ Сэтгүүлч. т 38

¹⁸ Ц.Жамбалсүрэн, Ю.Цэдэнбал: Ард түмэндээ хүргэх үнэн өчил. УБ., 1996. т 103

¹⁹ Ө.Дорж. Дурсамж, сургамж. 2002., т 45

дарга Төмөр-Очир, Засгийн газрын орлогч дарга Л.Цэнд, УБТЗ-н дарга Цогтсайхан нар Доржийг хамгаалж тус бүгд хурал дээр үг хэлжээ. "Ю.Цэдэнбал босч сэхээтнүүдийг дарга нар уриалж байгаад яриулсан гэж байна. Чөлөөтэй ярь гэж байгаад яриулсан гэдэг чинь ямар нэг хуурах санаа биш, хүмүүсийн үгэнд шинэ сайн зүйл олон байна, ялгаж үзэх хэрэгтэй. Шинэ мэдлэг шаардсан зүйл ч олон байх шиг байна гэж үг хэлж байтал Д.Дамба гуай зэрэгцэн босч үг хэллээ. Хоёр дарга маргаанд орлоо. Зэрэг ярьсан учир үг нь сайн дуулдахгүй жаал маргаж байгаад хоёулаа суудалдаа суулаа. ... Чухамдаа тавиад онд МАХН-ын ТХ-ны УТТ болон удирдлагад Д.Дамба, Б.Самдан, Д.Ламчин, Д.Самдан, С.Балган, Ч.Сүрэнжав, Б.Ширэндэв мэтийн хоцрогдсон догматикууд нуугдан бөөгнөрч манай урагшлан хөгжихөд саад болсоор Ю.Цэдэнбал, Д.Төмөр-Очир, Л.Цэнд, Ц.Дүгэрсүрэн, Ж.Самбуу нарын эсрэг тэмцэж байсан нь 1954 оны II сарын бүгд хүрлүүд (тарсан)-ын үеэс мэдэгдэх болсон юм ... Энэ байдал улам хурцадсаар 1959 оны 3-р сарын 30-31 нд хуралдсан III бүгд хурлаар Д.Дамба, Б.Дамдин, Д.Самдан, Д.Ламчин, С.Балган, Ч.Сүрэнжав нарыг намын удирдлагаас зайлуулсанаар "Сэхээтний төөрөгдөл" гэгчийг зохион хөөрөгдөгч том бүлэг цохигдсон"²⁰ гэж түүхэн бодит байдлын талаар бичжээ.

Тавиад оны "төөрөлдсөн сэхээтний" гол төлөөлөгч, хэд хэдэн удаа элдэв хэл ярианд орж хэлмэгдэж явсан үндэсний томоохон сэхээтэн Ц.Дамдинсүрэн нь амьдралын сүүлчийн жилүүдэд Ю.Цэдэнбалын үнэнч дотно хүн нь байж, дуртай үедээ утасдаж, уулзаж, хүсэл зоригоо хэлж шийдүүлж байсан ажээ. Нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай "сэхээтний төөрөгдлийн" үеэс л Б.Ширэндэвт дургүй байжээ. Тэрээр "Үндэсний соёлын өвийг хамгаалъя" гэсэн өгүүлэл бичиж Ширэндэвийг сайтар шүүмжилжээ. "Үнэн" сонин хэвлэж өгөхгүй болохоор Бал даргад хэлж, Бал сонинд утастаж, түүнийг хэвлүүлсэн нь²¹ тэр үедээ л тун сенсаци бүхий нийтлэл болж байжээ. Сургуульд хамт сурч байсан найзаасаа илүү дотно сэтгэлээр Ц.Дамдинсүрэнд ханддаг байсан уу, аль эсвэл хүний хэвлэн нийтлэх эрхийг бодсон уу, ямар ч л гэсэн тэр монголыг шуугиулсан өгүүлэлийг нь хэвлүүлж өгч байжээ.

Зууны гарамгай эрдэмтэн Б.Ринчен нь тавиад оны үед хохирон хэлмэгдэж явсан бодит хүн юм. Тэрээр анх хувьсгалын эсэргүү пан монголизмын тагнуулын байгууллагад оролцож, тагнуулын ба хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байсан гэдэг үндэсгүй шалтгаанаар 1937 онд баригдаж, 1939 оны 4 сарын 4 ний ДЯЯ-ны дэргэдэх комиссын шийдвэрээр буудан алах ял шийтгэгдэж байснаа өөрчилж, 10 жил хорихоор шийтгэгдсэн байжээ. 1941 оны 11 сард Б.Ринченг Маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын аман заавраар хорих ялыг нь өөрчлөн эрдэм соёл, ном бичин хэвлүүлэх үйлсэд түүний авъяас чадварыг ашиглаж эхэлжээ. Ийнхүү Ринчен, Цэдэнбал хоёрын харилцаа аятайхан эхэлжээ²².

МАХН-д 2 удаа элсэж, "баруунтан", "хувьсгалын эсэргүү", Японы "тагнуул" гэгдэн мөн 2 удаа намаас хөөгдөж, 1937 онд баригдаж, цаазлагдах ял оногдож яваад Х.Чойбалсан, Ю.Цэдэнбалын ачаар суллагдсан их эрдэмтэн Б.Ринчен нам, засгийн удирдагч нартаа баярлан талархаж, МАХН-д элсэх өргөдлөө 1945 оны IV сард Ю.Цэдэнбалын нэр дээр гаргаж байжээ²³. Олон жилийн турш ЗХУ, Монголын хүрээнд үндсэрхэх үзэлтэй гэгдэж байсан энэ хүнтэй болгоомжтой ханддаг байсан байж болох ч Ю.Цэдэнбал их эрдэмтэнд хүндэтгэлтэй ханддаг байсны жишээ баримт нилээд үлджээ²⁴.

²⁰ Мөн тэнд

²¹ Зохиогчийн хувийн архив

²² Монгол Post, 2001., III, №3

²³ Л.Бат-Очир. Чойбалсан. УБ., 1996, т 133-134

²⁴ Ю.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж. I боть, УБ., 2002. т 143; Ц.Жамбалсүрэн. Хүмүүнлэг энэрэнгүй ёс, хүний эрхийг хүндэтгэе. УБ., 2003. т 32-34

Б.Ринчен өөрт тохиолдсон аливаа асуудлыг Ю.Цэдэнбалд заавал хэлдэг, зөвлөдөг, тусыг нь авдагийг, бас зарим боловсон хүчний өөдгүй ажиллагааны талаар ойлгуулж бичдэг байжээ. Тавиад оны дунд үеэр намын зарим удирдагч түүнийг мөн л хавчин хохируулж байжээ. Ю.Цэдэнбалд итгэн найдаж бичсэн нэг захидалдаа их эрдэмтэн Б.Ринчен өөрийг нь элдвээр хавчин хяхаж, гүтгэн доромжилж байсан гол хүн бол Н.Лхамсүрэн байсан гэдгийг хангалттай нотлон үзүүлжээ. Тэрээр бичихдээ: "Д.Сэнгээ аймгуудаас олон захидал авч, уншигчтай хийсэн уулзалт дээр өөрийн нь нэрээ тавьж гаргасан Лхамсүрэнгийн гүжир зүйлийг буруушааж байгаатай тулгарахдаа нэрээ л тавьж гаргаснаас бус, санаа нь сонинд бичих даалгавар өгсөн хүнийх гэдгийг арга буюу хүлээн зөвшөөрсөн юм. Миний тэмдэглэлийн дэвтэрт "Сэнгээ дайрал зохиол бичсэнийхээ төлөө надаас уучлал эрлээ. Аргагүйн эрхэнд бичсэн гэж ам шүд алдлаа. НТХ-ны нарийн бичгийн дарга Намтайширийн Лхамсүрэнгийн даалгаврыг биелүүлснээ улайлаа гэсэн 1954 оны IX сарын 24 ний тэмдэглэл бий"²⁵ гэжээ. Б.Ринчен итгэж хүндэтгэдэг хүний хувьд, улс орны дээд удирдагчийн хувьд Ю.Цэдэнбалд удирдах зарим хүний үнэн нүүр царайг илчилж, Н.Лхамсүрэн нь эрдэм номоор нимгэн, улс төрийн хувьд ч будлиантай хүн болохыг тодорхойлж нилээн дэлгэрэнгүй захидал бичжээ. Н.Лхамсүрэн нь удалгүй 1957 онд НТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлөгдсөн нь их эрдэмтний дээрх шүүмжлэлтэй холбоотой байж болох юм.

Засгийн эрхийн төлөө, нам, засгийн тэр үеийн удирдлагын эсрэг хууль бус хуйвалдаан хийлээ гэж жараад оны эх дундуур олон хүний эрх ашгийг ямар нэг хэмжээгээр хөндөн ажлаас нь өөрчлөх, заримыг нь хөдөө томилж, "цөлөх", нутаг заан суулгаж байсан нь Ю.Цэдэнбалын үеийн хуучин тогтолцооны гажуудлын нэг хэлбэр байсныг бид хүлээж, шүүн ярилцаж, шинжлэх ухааны дүгнэлт хийж, сургамж авах ёстой.

Судалгаанаас үзэхэд тэр үед, нам түүний удирдлагын эсрэг тэмцэж явсан хүмүүс хэн нь ч ялгаагүй удирдлагад халаа сэлгээ хийж албан тушаалыг дахин хуваарилах, оршиж буй дутагдлыг арилгах зорилт тавьж байсан бөгөөд цөмөөрөө л марксизмын сургаальд чин үнэнчээ илэрхийлж, хувьсгалт намаа л бэхжүүлэх зорилт тавьж, социализмыг хурдан байгуулах, монгол улсаа мандуулахыг зорьж тэмцэж байсан болохоос аль нэгэн улс төрийн нам шинээр байгуулах, парламентийн засаглал тогтоох, Ерөнхийлөгчийг бүх ард түмнээр сонгох, улс орныг зах зээлийн эдийн засагт шилжүүлэн, өмчийг хувьчлах, долларыг чөлөөтэй болгох, Үндсэн хуулийн цэц байгуулах, сонгууль явуулахдаа нэг суудалд олон хүний нэр дэвшүүлэх, өөр үзэл суртлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэх мэт чөлөөт ардчилсан шаардлагуудыг хэн нь ч тавьж байсангүй. Харин ч жижиг хөрөнгөтний үзэл баримтлалаа гэж Ю.Цэдэнбалыгаа бут шүүмжилж байжээ. Олон жил үргэлжилсэн тэмцэл маргаанд түүхийн үнэн ялж, олон түмний дэмжлэг хүлээсний хувьд Ю.Цэдэнбал нь тэсэн үлджээ²⁶.

Социализмын үйлс, марксист-ленинист үзэл, монгол, зөвлөлтийн найрамдлын үзэл санаанд үнэнч байх хатуу чанга бодлого баримталж байсан энэ зүтгэлтэн хүний хувь заяаны асуудалд харин боломжийн хирээр хүнлэг зөөлөн хандаж байжээ. Хэлмэгдэн хохирсон төрийн гол зүтгэлтнүүд Ю.Цэдэнбалын үед цагаатгагдсан аж. Харин тавиад оны үед хэлмэгдүүллийн асуудлыг хэт хурцаар тавих, асуудлыг болгоомжгүй сэдрүүлэх нь монголчуудын дотоод эв нэгдлийн асуудалд муугаар нөлөөлж мэднэ гэж тэрээр нилээн болгоомжилж байжээ²⁷.

Зөрчил, ээдрээ, хөгжил цэцэглэл хосолсон XX зууны монголын түүхийн нэгэн томоохон зүтгэлтэн болсон энэ хүн алдаж, онохын аль алиныг амсаж,

²⁵ Б.Ринчен. Монголын за андагаар буй заа. УБ., 2000, т 319-325

²⁶ Өнөөдөр, 1997, №139-143-т үзнэ үү.

²⁷ Ю.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж. УБ., 2002. т 319-325

магтагдах, муулагдахын аль алиныг үзсэн, хүний л адил хүн байсан бөгөөд харин эрдэм мэдлэгийг шүтэх, мэргэжил боловсролоо дээшлүүлэх талаар ер бусын их чармайлт гаргаж байсан нь олон арван жил нам, төр, засгийн өндөрлөгт тэсэн тогтох чадавхийг түүнд өгчээ.

Энэ талаар түүний хамтран зүтгэгч, дотны нөхөд ч, нэгэн үе өрсөлдөн сөргөлдөж явсан хүмүүс ч, асуудалд бодитой ханддаг, тэр үеийн "нейтральный" хүмүүс ч сайнаар дурсан бичсэнтэй олонтаа тааралдаж болно.

Түүний талаар: "Цэдэнбал бага наснаасаа дотоод, гадаадын сургуульд суралцаж, эрдэм боловсролтой болж, улс орноо хөгжүүлэх үйл хэрэгт бүх хүчээ дайчилж яваа залуу боловсон хүчний нэг юм. Шинээр төрөн гарч байгаа өндөр боловсролтой, оюуны их чадвартай ... ийм шилдэг залуу боловсон хүчнийг зоригтой дэвшүүлж, итгэл үзүүлэх хэрэгтэй"²⁸, "Цэдэнбал үнэхээр ухаантай, эрдмийг шамдан сурсан шинэ хүчин, зав чөлөө бүхнийг ном уншихад зориулж мэдлэгээ ямагт дээшлүүлж байдаг"²⁹ (Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан. 1940); "Одоо намыг жолоодох хүн хэн байна? –Цэдэнбал гуай, - Өөр хүн байхгүй гэж үү? –өнөөхөндөө байхгүй. Цэдэнбал гуай бол онолын их мэдлэгтэй, үе үе гадаадад "цэнэглэгддэг", олон жилийн туршлагатай. – Цэ даргыг та хүртэл магтаж байна. Хожим муулах өдөр бий болов уу? – Хэнд эрх байна, түүнд алдаа бий. Гэвч даргын алдаа бүхнийг түүх цагаатгана"³⁰ /Доктор Д.Төмөр-Очир. Ю.Цэдэнбалын хамгийн хүчирхэг өрсөлдөгч, НТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга байгаад 1962 онд буруутгагдсан. Далаад онд хэлсэн;/ "Ю.Цэдэнбал ажлын үлэмж практиктай, мэдлэг чадвар сайтай зарчимч сайн хүн", "Тухайн үедээ л эрдэм чадлаар Цэдэнбал байсан юм"³¹ /Д.Дамба. НТХ-ны I нарийн бичгийн дарга байгаад 1959 онд шүүмжлэгдэж албан тушаалаас буусан /; "Ю.Цэдэнбал бол монгол төдийгүй дэлхийн олон улсад нэрд гарсан удирдагч хүн. Шинжлэх ухааны гүнгэгий мэдлэгтэй, их туршлага, авъяас билэгтэй хүн байсан"³², "Аугаа их мэдлэгтэй түүнтэй ажиллахад их, сайхан байсан"³³ /Доктор, профессор С.Жалан-Аажав. НТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга байсан, 1983 онд шүүмжлэгдэн албан тушаалаасаа буусан;/ "Юм үнэнээрээ байх сайхан, Тэр үнэхээр их уншдаг, их ажилладаг хүн байж. Бид Цэдэнбалд чирэгдэж явсан улс". /Академич, доктор, профессор Д.Даш. нам, төр, шинжлэх ухааны ахмад зүтгэлтэн;/ "Тухайн үедээ бидний дунд Цэдэнбал шиг мэдлэг боловсролтой удирдагч байгаагүй ... орой үдэш их суудаг байсан"³⁴ /доктор Д.Майдар. НТХ-ны УТТ-ны гишүүн, шинжлэх ухаан, техникийн улсын хорооны дарга байсан/ гэжээ.

"Хичээлээ өдөр шөнөгүй хийдэг сурлага сайтай хүүхэд байсан... тэр надаас өмнө төгсөж ажиллаж эхэлсэн болохоор мэдлэг чадвараар надаас илүү тул надад зааж сургаж өгдөг байлаа... ном их уншдаг хүн байж билээ"³⁵. /Академич, доктор, профессор Б.Ширэндэв. ШУА-ийн Ерөнхийлөгчөөр 20 жил ажилласан. 1982 онд шүүмжлэгдэж ажлаас буусан. Ю.Цэдэнбалын багын найз, хожмын өрсөлдөгч;/ "Цэдэнбал гуай түүхийн асар их боловсролтой, түүхийн холбогдолтой ном зохиол их уншдаг. Би түүнээс ухаалаг зан чанар, улс төр, эдийн засгийн мэргэн ухаан цөмийг нь олж хардаг байсан"³⁶. /Академич, доктор, профессор Ч.Далай. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал байсан;/ "Улс төр, нийгэм, эдийн засгийн өндөр боловсролтой. Түүний бичгийн соёл, уншсан

²⁸ П.Шагдарсүрэн. Миний мэдэх маршал Чойбалсан. УБ., 2000, т. 42

²⁹ Хүмүүн толь, 1993., VIII, № 1

³⁰ Өнөөдөр, 1998., № 48

³¹ Ж.Болдбаатар. Миний "хоцрогдсоныг" дэлхий мэднэ. Булган, 1994., т 79, 109

³² Хүмүүн толь, 1994., № 2

³³ Есөн туг /Ю.Цэдэнбал Академийн сонин/, 2002 № 3, 4

³⁴ Ардын эрх. 1991.4.8

³⁵ Ю.Цэдэнбал. Хүмүүсийн дурсамж. УБ., 2002. т 277-278.

³⁶ Мөн тэнд, т. 92

сонссон мэдлэг, орос хэлний чадвар, итгүүлэх дайчлах арга, хүнлэг энгийн зан төлөвд нь би л лав биширдэг"³⁷. /Доктор, профессор Ц.Балхаажав. НТХ-ны нарийн бичгийн дарга байсан/; "Цэ дарга маш их ном, сэтгүүл уншдаг, түүнийгээ үргэлж бясалгаж, бодож боловсруулж явдаг хүн байсан. Өндөр боловсролтой. Их соёлтой хүмүүсийн нэг. Асар их мэдлэгтэй, дэндүү хөдөлмөрч хүн байсан. Бүх биенийхээ хүч чадал, цэцэн ухааныг ганцхан Монголын төлөө зориулсан цорын ганц хүн гэж хэлж болно"³⁸. /Доктор М.Пэлжээ. СнЗ-ийн орлогч дарга байсан/; "Ю.Цэдэнбал бол манай улсын өргөн мэдлэг, өндөр боловсролтой цөөхөн сэхээтнүүдийн нэг байсан төдийгүй, сүүлдээ улс орныг удирдах арга ухааныг муугүй эзэмшсэн, улс төрийн стратеги тактикийг сайн мэддэг, манайдаа тэргүүн зэргийн улс төрч, онолч байсныг үгүйсгэвэл төдий л үнэмшилтэй бус, үнэнийг гуйвуулсан болох биз"³⁹. /Доктор Ц.Гүрбадам. 1984 оны эргэлтийн үед ЗХУ-д элчин сайдаар ажиллаж байсан/; "Ю.Цэдэнбал бол Монголын түүхэн дэх аугаа их соён гэгээрүүлэгч мөн сургуулиа түүний нэрэмжит болгож хөшөө дурсгалыг нь босгохоор шийдсэн юм"⁴⁰. /Доктор Б.Эрдэнэбат. МАШСН-ын дарга, нэрт бизнесмен/ гэж бичигчээснээс үзэхэд Ю.Цэдэнбал эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч, соёл боловсролын салбарт олон талтай өөрчлөлт хийсэн шинэчлэгч байсан гэж хэлж болохоор байна.

Ю.Цэдэнбалтай олон жил хамтран ажилласан, 1984 оны эргэлтийн тараа МАХН-ын ТХ-ны өрөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга болсон, доктор, профессор Ж.Батмөнх гуай бичихдээ: "Ю.Цэдэнбал мэдлэг боловсролын суурь сайтай, их хөдөлмөрч, маш тэвчээртэй, зан харилцааны хувьд эелдэг, хүнийг өөртөө татах увьдастай, өөрийн гэсэн маш хатуу дэг журамтай нэгэн байсан гэж би боддог. Энэ нь ялангуяа албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бүр ч тод илэрнэ. Харин жирийн цагт хошин шог ярих зэргээр оюуны алжаалаа тайлах дуртай. Тэр их уншдаг. Тиймээс түүнд чөлөөтэй цаг тун бага байсан... ярьж хөөрөх, санаа бодлоо илэрхийлэхдээ хэлэх үгээ маш цэнэж, туйлын болгоомжтой хандана. Орос хэлийг гарамгай эзэмшсэн"⁴¹ зэргээр бичжээ.

Ю.Цэдэнбалын найз нөхөд, хамтран зүтгэгчид, цаг цагийн өрсөлдөн тэмцэлдэгчид, монголын оюуны сор болсон хүмүүс түүнийг янз бүрийн цаг үед олон талаас нь шүүмжлэн хэлэлцэж байсан боловч эх орныхоо соёл боловсролыг хөгжүүлэх, эрдэм боловсролыг шүтэн эрхэмлэх талаарх Ю.Цэдэнбалын байр байдал, бодлого, үйл ажиллагааг гол төлөв эерэгээр үнэлж, сурч боловсрох, мэдлэг эзэмших талаар тухайн цаг үеийн өндөрлөгт байж чадсан гэж үзэж ирснийг цааш нь нарийн судлах хэрэгтэй гэж бодож байна.

1997 онд Ю.Цэдэнбалын цол, хэргэмийг эргүүлж олгохыг нэхэн шаардсан Төрийн шагналт, Гавъяатан, академич, доктор, профессор, дэд доктор, дэд профессор 136 хүний төр, засаг, ард түмэндээ хандсан 14 хуудас захидал уриалга⁴², ард түмнээсээ зууны алдартнаар өргөмжлөгдсөн өндөр нэр хүндтэй хүмүүс 2001 онд Ю.Цэдэнбалын дурсгалыг мөнхжүүлэх санал дэвшүүлсэн⁴³. 2003 онд Зууны эрдэмтэд академичид, шинжлэх ухаан, боловсролын зохион байгуулагчид 86 хүнээс ард түмэн, төр засагтаа хандсан "Ю.Цэдэнбалын өв

³⁷ Бүтээлч үйлсийн тод мөр: намын ахмадуудын дурсамж. УБ., 2001, т. 338

³⁸ Үнэн. 2001.8.17

³⁹ Зохиогчийн хувийн архив

⁴⁰ Ю.Цэдэнбалын хөшөөний нээлтэнд Б.Эрдэнэбатын хэлсэн үг. ЗХА

⁴¹ Ж.Батмөнх. Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй

⁴² Хүнийг хайрлан хүндэтгэх ариун дээд эрмэлзлэлийг эрхэмлэе. Ю.Цэдэнбалыг хамгаалж 136 академич, доктор, профессоруудын өргөсөн захидал. –Дал, 1997, Цагаагчин гахай сарын шинийн нэгэн

⁴³ Үнэн., 200-11-23

дурсгалын тухай" 13 хуудас түүхэн баримт бичиг гаргасан⁴⁴ зэрэг нь Монголын соёл, боловсрол, шинжлэх ухааны сор болсон эрдэмтэн мэргэд Монголын түүхийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбалын дурсгалд хүндэтгэлтэй ханддагийн тод томруун жишээ болсон юм.

Ю.Цэдэнбал эрдэм номд биеэ боловсруулахын төлөө насан туршдаа ажиллаж, тухайн цаг үеийнхээ түвшинд байхыг цаг ямагт чармайдаг байсан нь нам, төр, засгийн өндөрлөгт олон арван жил тэсэн тогтохын гол үндэс болжээ. Энэ дуурайлал өнөөгийн залуу удирдагчдад, нийт хүмүүст нэн сургамжтай юм. Ийм ч учраас манай шинжлэх ухааны байгууллагууд, их, дээд сургуулиуд дээр Цэдэнбал судлалыг хөгжүүлэх саналыг би дэвшүүлж байгаа юм.

ABSTRACT:

This article is about the contribution of Uy.Tsedenbal who head led MPRP and Mongolian state for 44 years to the development of culture, education and science.

⁴⁴ Монголын нам, засаг, төр цэргийн нэрт зүтгэлтэн, Улсын Баатар, Хөдөлмөрийн Баатар, Улсын маршал Ю.Цэдэнбалын өв дурсгалын тухай. Зууны эрдэмтэд, академичид, алдартнуудын уриалга. УБ., 2003., 39 х